

## 11- р сар

- I. Төсвийн орлого
- II. Төсвийн орлого, /сумаар/
- III. Төсвийн зарлага
- IV. Банкны кассын орлого зарлага, зээл хадгаламж
- V. Ажил хайгч иргэд
- VI. Бүртгэлтэй ажилгүйчүүд, ажлын байрны зуучлал
- VII. Нийгмийн даатгалын орлого
- VIII. Нийгмийн даатгалын орлого, зарлага
- IX. Хэрэглээний үнийн индекс
- X. Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ
- XI. Аж үйлдвэрийн үнэ
- XII. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
- XIII. Хүн амын ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
- XIV. Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
- XV. Нийгмийн халамж
- XVI. ХАА бүтээгдэхүүний үнэ
- XVII. Төл мал бойжилт
- XVIII. Ургац хураалт
- XIX. Гэмт хэргийн мэдээ
- XX. Гэмт хэрэг зөрчил (сумдаар)

## Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2018 оны 11 сарын байдлаар)

### I.Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2018 оны 11-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 99.4 хувьтай буюу 6967.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 103.4 хувьтай буюу 1742.7 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 8710.3 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 100.1 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 37566.4 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 99.8 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 6516.3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 22260.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1821.9 сая төгрөг нийт 30598.9 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Луус, Дэлгэрхангай, Сайнцагаан, Адаацаг сумд 4.8-131.4 хувиар буюу 3.5-543.9 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн бол бусад сумд төлөвлөгөөгөө 6.9-64.4 хувиар тасалдуулсан байна.

## II.Төсвийн зарлага



2018 оны 11 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 33667 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 16793.9 сая төгрөг болж нийт зардлын 49.9хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 12.4 хувиар өсч 2002.9 сая төгрөг болсон байна. Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үеэс эд хогшил урсгал засварын зардал 52.4 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 33.8 хувиар өссөн байна. Мөн засгийн газрын дотоод шилжүүлэг, хангамжийн бараа материалын зардал, томилолтын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хөрөнгийн зардал өмнөх оны мөн үеэс өссөн бол бараа норматив зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлэг 2.4-13.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

## III.Банк



Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 14.9 хувиар өсч 111278.8 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 678.1 сая төгрөг, чанаргүй зээл 1044.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 7.5 хувиар буурч, чанаргүй зээл 53 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1.5 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн

хувийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 31.5 хувиар өсч 50667.4 сая төгрөг болов.

#### **IV.Бүртгэлтэй ажилгүйчүүд**



2018 оны 11 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажил хайж байгаа 594хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс16.7хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 53.5 хувь буюу 318нь эмэгтэйчүүд байна.Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 195ажилгүйчүүд ногдож байхадГовь-Угтаал 655, Гурвансайхан 214, , Өлзийт 216, Өндөршил 216, Сайнцагаан 209 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.Ажил хайгч иргэдийн 22.0хувь нь дипломын болон бакалаврын дээд, 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 7.0 хувь нь техникийн болон мэргэжлийн, 39.0 хувь нь бүрэн дунд, 18.0 хувь нь суурь, 7.0 хувь нь бага, 3.0 хувь нь боловсролгүй иргэд байна.

#### **V.Ажлын байрны зуучлал**



Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2018 оны 11 сарын мэдээгээр нийт614хүн ажлын байранд зуучлагдсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 11.4 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 33.2 хувь, Төрийн удирдлага батлан хамгаалахын салбарт 5.0 хувь, боловсролын салбарт 11.9 хувь, санхүү даатгалын салбарт тус бүр 2.3 хувь нь зуучлагдсан бол үлдсэн хувь ньхөдөө аж ахуй,уул уурхай, эрүүл мэнд, урлаг соёлын салбарт зуучлагджээ.

## **VI. Нийгмийн халамж**



2018 оны эхний 11 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 15134 хүнд 5371,5 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчдын 29.9% буюу 4518 нь алдарт эхийн одонтой эхчүүд бөгөөд 626.5 сая төг, 16.4 % буюу 2475 нь насны хишиг тэтгэмж авч буй ахмадууд 430.9 сая төг, 19.2% буюу 2909 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүдэд 1156.3 сая төг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 932 иргэнд 536.6 сая төгрөг, Халамжийн тэтгэвэрийг 826 иргэнд 1218.7 сая төгрөг, жирэмсэн нярай, хөхүүл хүүхэдтэй 1245 эхэд 166.0 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон байна.

## **VII. Нийгмийн даатгал**



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 11 сарын байдлаар 27000.4 сая төгрөг, зарлага 27100.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 1315.8 сая төгрөгөөр, зарлага 2473.2 сая төгрөг буюу 15.5 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2018 оны эхний 11 сарын байдлаар 10875 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2421.0 хүн буюу 22.3 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 4194 хүн буюу 38.6 хувь нь төсөвт байгууллагаас, 4260 хүн буюу 39.1 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сайн дурын даатгуулагч буурч, аж ахуй нэгж, байгууллага, төсөвт байгууллагын даатгуулагч өссөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2018 оны эхний 11 сарын байдлаар 23460.0 сая төг болж, үүний 82.7 хувийг өндөр настны, 10.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.8 хувийг тэжээгчээ алдсаны, 3.5 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны эхний 11 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 6947 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 82.1 хувь буюу 5706 хүн өндөр насны, 12.5 хувь буюу 867 хүн тахир дутуугийн, 3.5 хувь буюу 246 хүн тэжээгчээ алдсаны, 1.8 хувь буюу 128 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Энэ оны эхний 11 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2263 ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 24, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 276 хүн байна.

Эхний 11 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 17970 байгаагийн 55.0 хувь буюу 9822 төр хариуцах иргэд, 28.3 хувь буюу 5084 малчид, 12.6 хувь буюу 2265 аж ахуйн нэгжийн эзэн,хувиараа хөдөлмөр эрхлэгч, 4.1 хувь буюу 739 оюутан суралцагчид байна.

2018 оны 11 сарын байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 9754,6 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 20.6 хувиар буюу 1664.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө

Гурвансайхан сумаас бусад бүх сумд давуулан биелүүлсэн байна.

### **VIII. Эрүүл мэнд**



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2018 оны 11 сарын байдлаар 834 эх төрсөн нь өнгөрсөн мөн үеэс 49 төрөлтөөр өссөн байна. Нийт 841 хүүхэд амьд төрсөн байна. Төрсөн эхчүүдийн 90.7хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ оны байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

2018 оны 11 сарын байдлаар 1 хүртлэх насны нялхсын эндэгдэл 7 байгаань Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Гурвансайхан, Цагаандэлгэр, Хулдсум болон аймгийн нэгдсэн эмнэлэгт бүртгэгдсэн байна. Нас баралтын 246 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 37 тохиолдлоор өсчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр 32.5хувийг эзэлж байна.

Оны эхний 11 сарын байдлаар стационарит шинээр 10105 эмчлүүлэгч хэвтэж, 10124 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 72898 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.2 байна. 2018 оны 11 сарын байдлаар 159614 үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 30.6%, амбулаторийн үзлэг 45.5%, идэвхтэй хяналт 16.4%, гэрийн үзлэг 5.2 %, гэрийн дуудлага 2.3%-ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.9хувь нь эрэгтэй, 64.1 хувь нь эмэгтэй хүн байна. Халдвар төвчний 329 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 105 тохиолдлоор

буурч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 71.6 болж өмнөх оны мөн үеэс 24.3 хувиар буурсан байна.

## **IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс**



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2018 оны 11-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2017 оны 11-р сартай харьцуулахад 6.5 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 6.5 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 6.6 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 9.7 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 8.0 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 6.1 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 5.1 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 13.0, тээврийн бүлэг 6.7 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

2018 оны 11 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлш болон ноолуурын үнийг орууллаа.

### **ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/**

№	Барааны нэр, төрөл	XI/07	XI/14	XI/21	XI/28
1	Гурил, 1-р зэрэг, кг	1200	1200	1200	1200
2	Хонины мах, кг	5500	5500	5500	5500
3	Үхрийн мах, кг	0	0	0	0

4	Ямааны ястай мах, кг	5000	5000	5000	5000
5	Элсэн чихэр, кг	1760	1760	1800	1800
6	Цагаан будаа, кг	2200	2200	2330	2330
7	Шингэн сүү, л	3000	3000	3000	3000
8	Ноолуурын үнэ 1 кг	85000	85000	85000	85000
9	Бензин А-80, 1литр	1950	1950	1950	1950
10	Бензин А-92, 1литр	2090	2090	2090	2090
11	Дизель түлш 1 литр	2530	2530	2525	2525

## **Х.Хөдөө аж ахуй**



2018 оны эхний 11 сарын байдлаар оны эхний төллөх насны хээлтэгч малын 79.4 хувь буюу 1193.1 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төл 92.6 хувь буюу 1106.4 мянган төл бойжиж байна.

Энэ оны эхний 11 сарын байдлаар 47150 толгой мал хорогдоод байна. Үүний 52.4 хувь нь ямаа, 34.4 хувь нь хонь, 13.2 хувийг бод малын хорогдол эзэлж байна. Нийт хорогдсон том малын 25.5 хувь нь хээлтэгч мал байна.

2018 оны 11 сарын байдлаар нийт 20,1 га-д төмс, 13,2 га-д хүнсний ногоо тариалж, 11 сарын 1-ны байдлаар 125.1 тн төмс, 61.0 тн хүнсний ногоо хураан аваад байна. мөн өөрийн хүчээр 5640.7 тн гар тэжээл бэлтгэсэн байна.

## **XI. Аж үйлдвэр**



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2018 оны 11 сарын байдлаар 7765.2 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 9.9 хувиар өссөн байна.

## XII. Гэмт хэрэг



Цагдаагийн хэлтсийн 2018 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 262 болж өнгөрсөн оны мөн үе тэй харьцуулахад 23 хувь өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.2 хувиар өсч, 163 хүн холбогдоод байна. 2018 оны эхний 11 сарын байдлаар танхайрах, булаалт, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс, хүчингийн хэрэг, бусдын эд хөрөнгийн хулгайн хэрэг, залилангийн хэрэг, малын хулгайн хэрэг нэмэгдсэн байна. Харин тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын хэрэг, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг буурсан байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 29.4 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын хэрэг, 39.3 хувийг хулгайн хэрэг, 6.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг, 1.5 хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг, 6.9 хувийг малын хулгайлах гэмт хэрэг, 2.3 хувийг хүчиндэх, залилангийн хэрэг 3.8 хувийг, 0.4 хувийг дээрмийн хэрэг, 10.3 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 15.6 хувийг согтуугаар, 4.6 хувийг эмэгтэй хүн оролцсон, 8.4 хувийг бүлэглэж, 4.6 хувийг хүүхэд оролцож хэрэг үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 86 хүн байхад

Дэлгэрцогт 145, Сайнцагаан 111, Баянжаргалан 146, Хулд 136 байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 834 сая төгрөг, түүний 32.3 хувь буюу 269.2 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 14 хувиар буурч 49.8 болсон байна.

### **XIII. Байгаль орчин**



#### **ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ**

Энэ сарын агаарын температурын дундаж нь 12-17 градус хүйтэн буюу нутгийн зүүн хэсгээр уур амьсгалын дунджаас 0.5-1.0 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр хүйтний эрч бага зэрэг суларч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 19-24 градус, өдөртөө 7-12 градус, бусад нутгаар шөнөдөө 13-18 градус, өдөртөө 3-8 градус хүйтэн байна. Нэгдүгээр арав хоногийн эхний хагаст ихэнх нутгаар хүйтний эрч чангарна. Гуравдугаар арав хоногийн дунд үеэр хүйтний эрч чангарч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 29-34 градус, өдөртөө 17-22 градус, бусад нутгаар шөнөдөө 24-29 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 24-29 градус, өдөртөө 14-19 градус хүйтэн байх төлөвтэй.

Энэ сард нутгийн зүүн хэсгээр уур амьсгалын дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар цас орж, шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй. Гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр нутгийн хойд хэсгээр бага зэргийн цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар 18-20 м/с хүрч ширүүсэх төлөвтэй.

I.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр

2018.12.10

Үзүүлэлт	мөр	2017 XI	2018 XI			18/17
			төл	гүйц	хувь	хувь
Нийт орлого						
/тусламжийн дүн/ А.УРСГАЛ ОРЛОГО	1	35017906.5	37632644.3	37566410.5	99.8	107.3
А.УРСГАЛ ОРЛОГО	2	5951783.1	6857012.2	6931266.8	101.1	116.5
I.ТАТВАРЫНОРЛОГО	3	3916747.2	4508396.5	4321724.3	95.9	110.3
1.1 Хүн амынорлогын албан татвар	4	2941096.2	3586288.6	3051607.4	85.1	103.8
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар		2893389.6	3313214.1	2755704.2	83.2	95.2
Хувь хүний орлогын албан татварын буцаалт		-436797.4	-450000.0	-427269.9	94.9	97.8
1.2 Үйл ажиллагааны орлого	5	433790.5	305215.6	238209.3	78.0	54.9
1.3 Хөрөнгө борлуулсаны	6	38787.4	45000.0	31735.5	70.5	81.8
1.4 Бусад татвар	8	11926.1	372858.9	453228.3	121.6	-
2.Хөрөнгийн татвар /ҮХХБолон буу/	9	85213.1	106028.1	119979.4	113.2	140.8
3. Авто тээврийн хэрэгслийн	12	235884.6	244439.3	241439.5	98.8	102.4
4. Бусад татвар	13	654553.3	571640.5	908698.0	159.0	138.8
4.1 Улсын тэмдэгийн	14	125963.3	113743.7	168720.8	148.3	133.9
4.2 Ашигт малтмал нөөцийн	15	18090.5	26048.2	48449.2	186.0	267.8
4.3 Газрын төлбөр	16	164373.3	190360.0	211144.5	110.9	128.5
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	17	17735.2	40120.8	13709.8	34.2	77.3
4.6 Усны төлбөр	18	13958.5	24410.0	44665.7	183.0	320.0
4.7 Лиценцийн төлбөр	19	0.0	0.0	0.0	-	-
4.6.Бусад	20	314432.5	176957.8	422008.0	238.5	134.2
II.ТАТВАРЫНБУСОРЛОГО	19	2035035.9	2348615.7	2609542.5	111.1	101.6
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	22	1678701.9	1980248.0	2143785.6	108.3	127.7
2.2 Бусад нэр заагдаагүй	23	356334.0	368367.7	465756.9	126.4	130.7
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	24	22512.2	156000.0	36287.0	23.3	161.2
В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	26	29043611.2	30619632.1	30598856.7	99.9	105.4
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	28	5443187.1	6516259.9	6516259.8	100.0	119.7
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		21753661.2	22260687.7	22260687.9	100.0	102.3
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих		1846762.9	1842684.5	1821909	98.9	98.7
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	29	5974295.3	7013012.2	6967553.8	99.4	116.6
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	30	2146139.9	1685288.4	1742727.6	103.4	81.2
Аймгийн нийт орлого	31	8120435.2	8698300.6	8710281.4	100.1	107.3

## II.Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2018.12.11

Сумд	2018 I-X			2018 X сар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дэлгэрцогт	103093.7	117931.0	114.4	8690.0	8139.6	93.7
Дэрэн	116365.9	136023.6	116.9	19178.9	8397.4	43.8
Говь-Угтаал	244597.7	136296.9	55.7	23200.0	9120.1	39.3
Цагаандэлгэр	80276.9	83790.0	104.4	7725.0	4194.0	54.3
Баянжаргалан	414002.0	957896.5	231.4	70888.2	351656.1	496.1
Өндөршил	130969.0	177381.0	135.4	10923.9	41819.1	382.8
Гурвансайхан	952626.0	338672.3	35.6	187739.2	24089.8	12.8
Өлзийт	292380.9	194175.9	66.4	22689.6	14415.8	63.5
Хулд	213860.2	168130.9	78.6	19770.0	13072.9	66.1
Луус	100949.1	125555.7	124.4	9327.0	9306.9	99.8
Дэлгэрхангай	160137.0	251490.6	157.0	14947.3	33897.7	226.8
Сайхан-Овоо	128949.3	120093.9	93.1	12894.2	20004.2	155.1
Эрдэнэдалай	305272.7	264668.0	86.7	33290.0	27784.7	83.5
Сайнцагаан	572123.3	599462.0	104.8	38226.0	32229.3	84.3
Адаацаг	114983.6	183168.139	159.3	10700.0	7824.7	73.1
Дундговь	2817018.3	2930234.9	104.0	312098.0	339823.1	108.9
Дүн	6747605.6	6784971.1	100.6	802287.3	945775.4	117.9

III.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2018.12.10

Зарлагын төрөл	2017 XI	2018 XI			18 XI/17 XI
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Орон нутгийн байгууллагын зарлагын дүн	32971175.6	40001095.2	33666986.0	84.2	102.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16288674.2	17624346.0	16793868.4	95.3	103.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1781280.4	2105267.4	2002911.3	95.3	112.4
Байр ашиглалттай холбоотой тогмол зардал	2643582.7	3322564.8	2849609.7	95.1	107.8
Хангамж бараа материалын зардал	542182.5	725701.6	662850.3	91.3	122.3
Норматив зардал	1122918.6	1276489.8	1096437.9	85.9	97.6
Эд хогшил урсгал засварын зардал	284045.1	631847.2	432854.3	68.5	152.4
Томилолтын зардал	122256.1	150597.2	135260.4	89.8	110.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	688311.2	1059412.9	921251.1	87.0	133.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1913829.4	3721726.9	1658078.0	44.6	86.6
Засгийн газрын дотоод шилжүүлэг	184752.6	242050.6	242050.6	100.0	131.0
Бусад урсгал шилжүүлэг	4992433.8	4963742.0	4371487.3	88.1	87.6
Хөрөнгийн зардал	2406909	4177348.8	2500326.7	59.9	103.9

**IV.БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН  
МЭДЭЭ, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр**

2018.12.11

№	Үзүүлэлт	ХААН банк		Хас банк		Төрийн банк		Капитал банк		Бүгд		
		2017 XI	2018 XI	2017 XI	2018 XI	2017 XI	2018 XI	2017XI	2018XI	2017 XI	2018 XI	2018/ 2017 хувь
1	Кассын орлого	9,629.20	9,915.60	1263.5	1198.9	8844.4	8691.1	0.0	0.0	19737.1	19805.6	100.3
	Зузаатга лаар											
2	Кассын зарлага	10,044.90	10,430.80	2585.7	3449.1	4609.8	5669.0	353.9	192.2	17594.3	19741.1	112.2
	шилжүүлсэн											
3	Зээлийн өрийн үлдэгдэл	57973.6	59868.4	11209.2	12419.1	27616.7	38991.3	36.7	0.0	96836.2	111278.8	114.9
	үүнээс: Анхаарал хандуулах зээл	270.2	271.4	413.0	287.4	49.6	119.3	0.0	0.0	732.8	678.1	92.5
4	чанаргүй зээл	392.8	378.1	202.3	579.0	68.0	87.1	19.3	0.0	682.4	1044.2	153.0
	Иргэдийн хувийн хадгаламжийн үлдэгдэл	24512.8	35457.9	4236.1	4158.2	9469.5	11051.3	309.5	0.0	38527.9	50667.4	131.5

## V. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2018.12.04

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд	Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд
Дэлгэрцогт	1106	15	18	10	163
Дэрэн	1363	9	25	10	183
Говь-Угтаал	1068	72	70	32	655
Цагаандэлгэр	694	10	5	3	72
Баянжаргалан	756	6	16	7	212
Өндөршил	973	19	21	9	216
Гурвансайхан	1449	31	31	9	214
Өлзийт	1607	41	38	19	236
Хулд	1612	23	43	26	267
Луус	1239	18	25	11	202
Дэлгэрхангай	1489	26	22	15	148
Сайхан-Овоо	1470	15	15	10	102
Эрдэнэдалай	3685	29	30	21	81
Сайнцагаан	10074	139	211	121	209
Адаацаг	1943	23	24	15	124
Дүн	30528	476	594	318	195

## VI. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2018 оны эхний 11 сарын байдлаар

2018.12.04

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	49.0	14.0	8.0
Уул уурхай олборлох үйлдвэр	58.0	16.0	9.4
Боловсруулах аж үйлдвэр	6.0	2.0	1.0
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	18.0	3.0	2.9
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	3.0	1.0	0.5
Барилга	25.0	1.0	4.1
Бөөний ба жижиглэн худалдаа	23.0	15.0	3.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Зочид буудал, зоогийн газар	0.0	0.0	0.0
Мэдээлэл холбоо	2.0	1.0	0.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	14.0	11.0	2.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.0	3.0	0.5
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.0	1.0	0.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	70.0	24.0	11.4
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	31.0	16.0	5.0
Боловсрол	73.0	52.0	11.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	25.0	14.0	4.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	9.0	5.0	1.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	204.0	84.0	33.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Бүгд	614.0	263.0	100.0

VII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВРИЙН САНХҮҮЖИЛТ, 2018 оны  
эхний 11 сарын байдлаар

2018.12.05

Сумд	Н.Д.Шимтгэлийн орлого /мян.төг/			Тэтгэврийн санхүүжилт /мян.төг/		
	төл	гүйц	хувь	олгох	олгосон	хувь
Дэлгэрцогт	155228.1	222396.9	143.3	950273.9	950273.9	100.0
Дэрэн	154957.8	224716.2	145.0	1012195.4	1012195.4	100.0
Говь-Угтаал	192463.1	283557.2	147.3	838626.1	838626.1	100.0
Цагаандэлгэр	120455.2	154159.6	128.0	475463.5	475463.5	100.0
Баянжаргалан	228056.6	276565.7	121.3	492931.3	492931.3	100.0
Өндөршил	175800.5	245611.9	139.7	665217.3	665217.3	100.0
Гурвансайхан	322819.0	258855.5	80.2	908194.7	908194.7	100.0
Өлзийт	189111.0	288561.6	152.6	155199.7	155199.7	100.0
Хулд	232043.3	315785.6	136.1	1088045.4	1088045.4	100.0
Луус	184449.7	276951.4	150.2	920919.5	920919.5	100.0
Дэлгэрхангай	222292.6	326949.5	147.1	1083476.2	1083476.2	100.0
Сайхан-Овоо	156485.1	233784.2	149.4	875849.2	875849.2	100.0
Эрдэнэдалай	445379.0	662372.3	148.7	2799961.9	2799961.9	100.0
Адаацаг	217498.1	290722.7	133.7	1261960.2	1261960.2	100.0
Сайнцагаан	5093127.1	5693687.6	111.8	9004773.3	9004773.3	100.0
Дүн	8090166.2	9754677.9	120.6	22533087.6	22533087.6	100.0

VIII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

2018.12.12

/сая.төг/

	2017 оны XI сар	2018 оны XI сар			$\frac{2018 \text{ XI}}{2017 \text{ XI}}$ хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийгмийн даатгалын сангийн орлого	25684.6	8090.1	27000.4	333.7	105.1
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	21062.9	6747.9	23493.1	348.2	111.5
Тэтгэмжийн даатгалын сангийн	1035.2	734.6	1086.3	147.9	104.9
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2785.4	0.0	1656.6	#DIV/0!	59.5
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	489.0	468.4	478.7	102.2	97.9
Ажилгүйдлийн даатгалын сангийн	312.1	139.2	285.8	205.3	91.6
Нийгмийн даатгалын сангийн зарлага	24627.1	25931.1	27100.3	104.5	110.0
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	20306.6	24092.8	23460.0	97.4	115.5
Тэтгэмжийн даатгалын сангийн	1015.4	1101.5	1122.7	101.9	110.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2566.9	0.0	1762.4	#DIV/0!	68.7
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	455.9	417.3	470.0	112.6	103.1
Ажилгүйдлийн даатгалын сангийн	282.3	319.5	285.2	89.3	101.0

Тайлбар: \*Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

IX.НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

2018.12.12

Үзүүлэлтүүд	2016 оны XI сар	2017 оны XI сар	2018 оны XI сар	<u>2018 XI</u> <u>2017 XI</u> хувь
Заавал даатгуулагчийн тоо	12989	10840	10875	100.3
Үүнээс:				
Аж ахуйн нэгж, байгууллага	2319	2366	2421	102.3
Төсөвт байгууллага	4051	4128	4194	101.6
Сайн дурын	6619	4346	4260	98.0
Олгосон тэтгэвэр, сая төг	19131.3	20377.8	23460.0	115.1
Үүнээс:				
Өндөр настны	15639.0	16760.0	19409.5	115.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	2391.3	2435.2	2558.4	105.1
Тэжээгчээ алдсаны	567.2	596.3	657.7	110.3
Цэргийн	533.8	586.3	828.1	141.2

# XV. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

2018.12.10

IX. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Барааны бүлгээр	2018 XI 2017 XI	2018 XI 2017 XII
<b>ЕРӨНХИЙ ИНДЭКС</b>	<b>106.5</b>	<b>104.7</b>
<b>01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА</b>	<b>106.6</b>	<b>106.7</b>
01.1 ХҮНСНИЙ БАРАА	106.9	107.0
01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	101.7	101.4
01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН	128.3	128.4
01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН	100.0	100.0
01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ	105.8	105.9
01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС	99.7	101.0
01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ	106.3	108.3
01.1.7 ХҮНСНИЙ НОГОО	99.5	99.8
01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР	102.2	101.4
01.1.9 ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН	100.2	100.8
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	103.4	103.6
<b>02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС</b>	<b>109.7</b>	<b>109.4</b>
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	107.1	106.6
02.2 ТАМХИ	113.5	113.5
<b>03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ</b>	<b>108.0</b>	<b>106.3</b>
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	108.7	107.6
03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА	119.4	118.8
03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС	107.7	106.6
03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ	100.0	100.0
03.2 ГУТАЛ	106.5	103.6
<b>04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ</b>	<b>106.1</b>	<b>95.1</b>
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	131.8	131.8
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	105.0	104.6
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	106.2	89.9

Барааны бүлгээр		2018 XI 2017 XI	2018 XI 2017 XII
<b>05.</b>	<b>ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА</b>	<b>105.1</b>	<b>105.0</b>
	05.1 ГЭР АХУЙН ТАВИЛАГ, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	107.1	107.1
	05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	106.0	106.0
	05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	96.8	96.8
	05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	105.9	105.9
	05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	102.7	102.3
	05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД	106.6	106.3
<b>06.</b>	<b>ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>113.0</b>	<b>113.0</b>
	06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ	115.3	115.3
	06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
	06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
<b>07.</b>	<b>ТЭЭВЭР</b>	<b>106.7</b>	<b>107.2</b>
	07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	102.6	101.0
	07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	120.3	120.1
	07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	132.2	132.2
<b>08.</b>	<b>ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>101.5</b>	<b>101.5</b>
	08.2 ТЕЛЕФОН АППАРАТ, ФАКСЫН ХЭРЭГСЭЛ	100.0	100.0
	08.3 ТЕЛЕФОН УТАС, ФАКСЫН ҮЙЛЧИЛГЭЭ	101.6	101.6
<b>09.</b>	<b>АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>103.1</b>	<b>103.1</b>
	09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМ	102.1	102.1
	09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
	09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	106.5	106.5
<b>10.</b>	<b>БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>11.</b>	<b>ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>105.7</b>	<b>105.7</b>
	11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	102.0	102.0
	11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	108.0	108.0
<b>12.</b>	<b>БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ</b>	<b>99.3</b>	<b>99.3</b>
	12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	98.5	98.4
	12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	103.6	103.6
	12.5 ДААТГАЛ	100.0	100.0
	12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

ХИ. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 11-Р САРЫН ҮНИЙН  
МЭДЭЭ/аймгаар/

2018.12.11

	Нэр төрөл	Дундговь	Төв	Өмнөговь	Дорноговь
1	Гурил, дээд зэрэг /Алтантариа/	1575.0	1433.0	1647.0	1350.0
2	Гурил, 1-р зэрэг /Алтантариа/	1200.0	1150.0	1233.0	1100.0
3	Гурил, 2-р зэрэг /Алтантариа/	950.0	950.0	-	950.0
4	Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай	800.0	767.0	903.0	750.0
5	Талх, орон нутгийн үйлдвэрийн	1100.0	1200.0	1100.0	1400.0
6	Гурилан боов, 0.450г, /аймгийн үйлдвэрийн/	1650.0	1200.0	2433.0	2000.0
7	Жигнэмэг /Юбилейные 150- 180г, цайны/	1200.0	1233.0	1183.0	1200.0
8	Цагаан будаа, задгай, кг	2333.0	2367.0	2300.0	2233.0
9	Шар будаа, задгай, кг	1800.0	2000.0	2050.0	2433.0
10	Хонины мах, кг	5500.0	5167.0	5833.0	5833.0
11	Адууны мах, кг	6000.0	6333.0	6333.0	6000.0
12	Ямааны мах, кг	5000.0	4500.0	5333.0	4833.0
13	Дотор мах, цувдай, цусгүй	1500.0	2250.0	2667.0	2167.0
14	Хиам чанасан, 1кг	7633.0	8333.0	9433.0	6600.0
15	Сүү, задгай, л	3000.0	1600.0	4000.0	2000.0
16	Сүү савласан, 1л. Цэвэр сүү	2700.0	2667.0	2600.0	2567.0
17	Хорхой ааруул, задгай, чихэртэй	18000.0	13000.0	14500.0	14500.0
18	Өндөг, ш, дотоод	350.0	370.0	327.0	350.0
19	Ургамлын тос, 1литр, Кларина	3433.0	3933.0	3313.0	3100.0
20	Өөхөн тос, кг	-	1500.0	-	1500.0
21	Шар тос, кг	15000.0	20000.0	16500.0	16667.0
22	Цөцгийн тос, задгай, кг	3533.0	4000.0	3933.0	3400.0
23	Төмс дотоод, кг	950.0	800.0	1067.0	833.0
24	Лууван хятад, кг	1200.0	1300.0	1300.0	1500.0
25	Байцаа хятад, кг	900.0	1067.0	1267.0	1000.0
26	Сонгино хятад, кг	1133.0	1267.0	1267.0	1500.0
27	Элсэн чихэр, кг, орос	1800.0	1900.0	2100.0	2000.0
28	Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/	5500.0	5500.0	5600.0	5333.0
29	Зөөлөн чихэр, /Мишка/, кг	-	-	9333.0	-
30	Шоколад, "Alpen gold"	2200.0	2333.0	2057.0	1067.0
31	Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	1000.0	1000.0	767.0	717.0
32	Майноз, /Золотой 500г/	4500.0	4600.0	4533.0	4500.0
33	Кетчуп, 900г, Чили	2000.0	1867.0	1957.0	2000.0
34	Ногоон цай, Stimo, савласан 90г	1700.0	1700.0	1100.0	-
35	Байхуу цай, Акбар, 20 ширхэгтэй	1650.0	1700.0	1580.0	1567.0
36	Цагаан архи, 0.5 Ерөөл	8333.0	8567.0	8297.0	8767.0
37	Пиво, "Боргио", 0.5л	1650.0	1600.0	1883.0	1700.0
38	Янжуур тамхи, /West/, саарал	3000.0	2950.0	2917.0	2733.0
39	Янжуур тамхи, /Улаан шонхор/, Монгол тамхи	2100.0	1900.0	1883.0	1780.0
40	Бензин, А-80, 1 литр	1960.0	1833.0	1983.0	1947.0
41	Бензин, А-92, 1 литр	2090.0	1970.0	2125.0	2047.0
42	Дизель түлш, 1 литр	2525.0	2390.0	2525.0	2338.0

ХИИ. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ (оны үнээр)

2018.12.10

мян.төг

<b>Аж үйлдвэрийн салбар</b>	<b>2017</b>	<b>2018</b>	<b>2018/2017 хувь</b>
<b>Нийт дүн</b>	<b>7062626.3</b>	<b>7765163.5</b>	<b>109.9</b>
<b>Уул уурхайн олборлох аж үйлдвэр</b>	<b>2855643.4</b>	<b>2961109.1</b>	<b>103.7</b>
Нүүрс олборлолт	309901.8	306290.1	98.8
Гөлтгөнө	552994.2	503944.0	91.1
Жонш олборлолт	1992747.4	2150875.0	107.9
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>1060037.6</b>	<b>1127944.4</b>	<b>106.4</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	808072.2	873558.0	108.1
Хуснэгт маягт үйлдвэрлэл	15797.4	20257.9	128.2
Боловсруулах үйлдвэр бусад	236168.0	234128.5	99.1
<b>Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж</b>	<b>3146945.3</b>	<b>3676110.0</b>	<b>116.8</b>
<i>Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл</i>	2525588.0	3064227.1	121.3
Ус ариутгал ус хангамж	621357.3	611882.9	98.5

### XIII. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

2018.12.10

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2017 оны мөн үед	2018 онд	2018/2017 хувь
Хүрэн нүүрс	мян.тн	12.4	10.7	86.3
Жонш	мян.тн	11.2	8.5	75.9
Гөлтгөнө	мян.тн	31.1	19.9	64.0
Дулааны эрчим хүч	мян.гкал	79.9	71.8	89.9
Хүснэгт, маягт	х.д.х	226.0	289.2	128.0
Талх	тн	108.6	116.9	107.6
Нарийн боов	тн	108.7	98.2	90.3
Чихэр	тн	3.1	2.9	93.5
Архи	мян.л	25.3	26.4	104.3
Хиамны зүйл	тн	0.4	0.6	150.0
Сүү, тараг	мян.л	4.7	5.3	112.8
Хоормог	мян.л	0.0	0.4	-
Ааруул	тн	0.8	0.5	62.5
Вакум цонх	м <sup>2</sup>	187.0	207.0	110.7
Вакум хаалга	м <sup>2</sup>	33.0	57.0	172.7
Модон эдлэл	мян.төг	80443.0	138815.0	172.6
Түгээсэн цэвэр ус	мян.т <sup>3</sup>	112.1	109.0	97.2
Сувагжуулалт	мян.м <sup>3</sup>	71.5	76.1	106.4
Оёдол эсгүүр	мян.төг	56425.0	52542.0	93.1
Блок	мян.ш	20.0	7.2	36.0

#### XIV. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2018.12.05

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Дэлгэрцогт	0	1	9	9	0	1	0	1
Дэрэн	4	4	11	8	1	0	3	0
Говь-Угтаал	11	7	8	10	0	0	0	1
Цагаандэлгэр	2	0	3	4	1	0	1	1
Баянжаргалан	1	0	4	7	0	0	0	0
Өндөршил	2	4	7	4	0	0	0	0
Гурвансайхан	5	1	8	14	0	1	0	1
Өлзийт	4	4	5	7	0	0	0	0
Хулд	3	4	10	10	0	1	0	1
Луус	6	3	8	9	0	0	0	0
Дэлгэрхангай	7	10	13	19	1	1	1	1
Сайхан-Овоо	4	3	10	6	0	0	1	0
Эрдэнэдалай	34	21	29	26	0	0	1	0
Сайнцагаан	709	771	72	98	3	2	4	5
Адаацаг	6	8	12	15	0	1	1	1
Дүн	798	841	209	246	6	7	12	12

ХV. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

2018.12.05

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/							
							сүрьеэ		вируст гепатит		тэмбүү		трихомониаз	
							2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Дц	231	233	1967	1819	13	25	3	1	1	0	3	0	2	1
Дн	201	176	3949	2616	5	7	0	2	0	0	0	0	4	3
Гу	157	176	4174	3745	38	9	4	2	0	0	0	5	0	0
Цд	137	163	2216	2030	10	1	0	0	2	0	0	0	0	0
Бж	205	165	2091	2536	1	2	1	0	0	0	0	0	0	1
Өш	240	216	4695	3427	5	6	0	1	0	0	3	1	2	1
Гс	167	149	2424	3183	10	10	1	1	0	0	1	2	1	2
Өт	121	136	4182	3819	9	10	1	0	0	2	4	3	3	3
Хд	140	180	3590	2577	5	7	1	3	0	1	1	1	2	3
Лс	161	209	4441	2494	10	11	0	0	0	2	3	6	1	3
Дх	120	120	3683	3608	2	4	0	0	0	0	0	2	1	1
Со	176	182	2976	1842	3	6	0	2	0	1	0	1	0	0
Эд	580	493	10446	8858	20	4	5	0	1	0	0	2	0	2
Ад	259	240	10404	7762	8	8	4	3	0	2	0	2	3	0
Сц	5284	5608	103578	106488	295	219	14	16	3	3	28	33	32	28
Мд	471	394	508	421	0	0	0	0	0	0	0	0	0	0
Эб	389	377	284	282	0	0	0	0	0	0	0	0	0	0
МУЭ ТӨВ	854	888	2429	2107	0	0	0	0	0	0	0	0	0	0
ДҮН	9893	10105	168037	159614	434	329	34	31	7	11	43	58	51	48

\* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

XVI.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН МЭДЭЭ 2018 оны 11-р сар

2018.12.06

Мян.төг

Халамжийн төрүүд	хамрагдсан хүн	Гүйцэтгэл
<b>Халамжийн тэтгэвэр</b>	<b>826</b>	<b>1,218,757.60</b>
<b>Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>932</b>	<b>563,598.70</b>
<i>Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэнд олгох</i>	574	331,958.20
<i>Байнгын асаргаа шаардлагатай ХБ хүүхдийг асарч байгаа</i>	173	106,746.70
<i>Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид</i>	24	21,275.20
<i>Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа</i>	12	11,807.00
<i>Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа</i>	2	1,120.80
<i>Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа</i>	150	90,690.80
<b>Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж</b>	<b>1245</b>	<b>165,972.30</b>
<b>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ /38+...+43/</b>	<b>230</b>	<b>28,476.00</b>
<b>Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж /45+...+51/</b>	<b>750</b>	<b>368,891</b>
<i>Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн цэцэрлэгийн хоолны үнийн хөнгөлөлт</i>	0	0.00
<i>16 хүрэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж</i>	177	234,651.10
<i>3 хүртэлхи насны ихэр хүүхдэд жилд нэг удаа</i>	10	20,000.00
<i>Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа</i>	536	81,840.00
<i>3 ба түүнээс дээш тооны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа</i>	0	0.00
<i>18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа</i>	3	3,600.00
<i>Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа</i>	24	28,800.00
<b>0-03 насны хүүхэд асарсны тэтгэмж</b>	<b>2909</b>	<b>1,156,332.00</b>
<b>Өрх толгойлсон эцэг, эх</b>	<b>131</b>	<b>73,040.00</b>
<b>Хүнс тэжээл нийгмийн хамгаалалын хөтөлбөрт</b>	<b>0</b>	<b>226,776.00</b>
<b>Насны хишиг</b>	<b>2475</b>	<b>430,850.00</b>
<b>Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж</b>	<b>4518</b>	<b>626,460.00</b>
<b>Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж</b>	<b>997</b>	<b>373,707.30</b>
<b>Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж/</b>	<b>91</b>	<b>86,807.20</b>
<b>Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж, хөнгөлөлт</b>	<b>30</b>	<b>51,844.00</b>
<b>Зарлагын нийт дүн</b>	<b>15,134</b>	<b>5,371,512.20</b>

2018.12.12

## XVII. ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ

	Хэмж их нэгж	2018 он									
		3 р сар	4 р сар	5 р сар	6 р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	
1. Малын үнэ /мян.төг/											
Тэмээ											
Нас гүйцсэн	эр	1046.2	1162.5	1160.8	1025.4	1083.3	1075.0	1058.3	1066.7	1058.3	1087.5
	эм	861.5	929.2	922.5	792.3	895.8	900.0	908.3	891.7	908.3	883.3
Өсвөр насны	эр	595.8	670.8	665	610	642.3	626.9	607.7	603.8	607.7	627
	эм	620.8	629.2	625	583.3	625	612.5	591.7	587.5	591.7	604.2
Адуу											
Нас гүйцсэн	эр	740.8	737.9	750	675	696.4	721.4	706.7	667.9	706.7	792.8
	эм	644	665.4	684.6	614.3	646.4	664.3	656.7	623.3	656.7	723.3
Өсвөр насны	эр	497.2	527	523.1	465.4	487.5	484.6	517.9	515.4	517.9	573.1
	эм	489.4	519.2	503.8	457.7	475	462.5	491.7	495.8	491.7	505.8
Үхэр											
Нутгийн үүлдрийн, нас гүйцсэн	эр	998.7	988.5	996.2	953.8	917.7	921.5	941.4	882.2	941.4	1025
	эм	838.7	834.6	888.5	838.5	792.3	792.3	815.4	807.7	815.4	880.7
Өсвөр насны	эр	606.4	714.3	703.6	566.9	596.4	592.8	625	578.7	625	696.4
	эм	581.8	619.2	630.8	555.4	566.7	570.8	587.5	586.3	587.5	641
Хонь, Ямаа											
Нас гүйцсэн хонь	эр	134	144	153.8	140.7	135.3	138	136	128.7	136	148.7
	эм	92.7	98.5	103.6	98.6	92.1	92.1	94.3	88.3	94.3	99
Нас гүйцсэн ямаа	эр	95.3	102.5	106.8	97.9	95	96.6	100.3	69	100.3	123.3
	эм	74.6	79.2	78.8	69.6	67.5	70.7	71.7	65.7	71.7	88
2.Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ/мян.төг/											
Тэмээний ноос	кг	-				15.0	14	14	14.0	14	14
Ямааны ноолуур	кг	90.0	93.0	97	90.0	85	85	85.0	85	85	85
Тэмээний шир	ш	20.0	25.0	25.0	25.0	-					
Адууны шир	ш	20.0	0.0	0.0	0.0	-		8.0	8	9	
-2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир	ш	25.0	0.0	0.0	0.0	-		8.0	10	10	
-2 м- ээс дээш хэмжээтэй үхрийн шир	ш	30.0	0.0	0.0	0.0	-		12.0	14	14	
Хонины ноостой, өлөн гэдэстэй арьс	ш	5.0	4.0	4.0	5.0	1.5	1.5	3.0	3	2.5	
Ямааны ноолууртай, өлөнтэй арьс	ш	35.0	0.0	0.0	0.0	-		6.0	27	32	

### XVIII. Том малын зүй бус хорогдол, сумаар

2018.11.11

сумд	2017 онд	2018 оны эхний 10 сард хорогдсон том мал						Үүнээс: хорогдсон хээлтэгч мал					
		Бүгд	АДУУ	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	АДУУ	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Сайнцагаан	57	5260	368	423	2	1789	2678	1376	113	148	0	526	589
Адаацаг	287	18104	945	1193	4	6818	9144	1902	189	218	1	545	949
Баянжаргалан	127	59	0	21	0	19	19	10	0	2	0	3	5
Говь-Угтаал	405	3241	182	102	1	997	1959	719	102	44	0	262	311
Гурвансайхан	2	227	5	19	0	75	128	70	0	13	0	32	25
Дэлгэрхангай	0	451	41	63	14	130	203	237	17	30	12	72	106
Дэлгэрцогт	312	4221	389	314	1	1531	1986	2386	333	170	0	860	1023
Дэрэн	0	2411	225	93	0	812	1281	560	91	26	0	212	231
Луус	1	803	46	36	0	264	457	175	6	11	0	105	53
Өлзийт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Өндөршил	0	20	0	20	0	0	0	0	0	0	0	0	0
Сайхан-Овоо	56	1202	102	195	0	332	573	379	23	54	0	125	177
Хулд	0	2392	177	157	0	942	1116	2331	151	129	0	942	1109
Цагаандэлгэр	335	903	56	83	2	260	502	327	33	50	1	79	164
Эрдэнэдалай	245	7856	330	595	0	2248	4683	1544	82	164	0	477	821
<b>Бүгд</b>	<b>1827</b>	<b>47150</b>	<b>2866</b>	<b>3314</b>	<b>24</b>	<b>16217</b>	<b>24729</b>	<b>12016</b>	<b>1140</b>	<b>1059</b>	<b>14</b>	<b>4240</b>	<b>5563</b>

**XIX. Тариалсан талбай, хураасан ургацын мэдээ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**

2018.12.12

Сумдын нэр	2017				2018				2016 онд өөрийн хүчээр бэлтгэсэн өвс (тонн)	Бэлтгэсэн гар тэжээл (тонн)	
	Төмс		Хүнсний ногоо		Төмс		Хүнсний ногоо			2017	2018
	нийт тариалсан талбай (га)	нийт хураасан ургац (тонн)	нийт тариалсан талбай (га)	нийт хураасан ургац (тонн)	нийт тариалсан талбай (га)	нийт хураасан ургац (тонн)	нийт тариалсан талбай (га)	нийт хураасан ургац (тонн)			
Адаацаг	9.87	25.00	5.02	9.80	0.5	1.3	0.4	3.2	-	135.7	122.9
Баянжаргалан	1.00	1.90	0.50	1.30	0.3	2.0	0.8	5.0	-	95.0	33
Говь-Угтаал	0.50	0.50	0.50	0.50	0.1	4.6	0.3	4.1	-	14.5	62.3
Гурвансайхан	2.24	12.00	6.07	3.73	0.5	0.6	0.5	0.6	-	1100.0	77
Дэлгэрхангай	1.00	0.05	0.30	0.36	1.0	10.3	1.2	5.6	-	179.0	37.5
Дэлгэрцогт	5.10	5.40	0.79	5.70	1.5	10.2	0.8	1.8	-	126.4	456.4
Дэрэн	2.40	1.20	0.50	0.27	1.3	2.5	0.2	1.2	-	1263.0	565
Луус	1.99	2.99	0.44	1.41	0.0	0.6	0.0	0.6	-	102.0	65
Өндөршил	0.73	0.73	0.42	0.39	0.7	1.4	0.4	2.4	-	80.0	15
Өлзийт	2.00	1.10	0.30	0.42	0.4	0.6	0.4	0.3	-	155.4	43
Сайнцагаан	0.80	0.27	0.50	0.48	4.8	45.6	1.7	18.7	-	379.0	149.6
Сайхан-Овоо	5.30	26.50	1.60	8.47	5.3	26.5	2.2	13.2	-	590.0	70
Хулд	2.60	0.00	2.60	0.35	2.1	2.0	2.5	1.5	-	440.0	130
Цагаандэлгэр	0.50	5.00	0.30	0.60	0.3	2.0	0.4	0.8	-	61.0	64
Эрдэнэдалай	3.00	4.19	2.50	1.48	0.8	15.0	0.7	2.0	-	3840.0	3750
<b>Дүн</b>	<b>39.03</b>	<b>86.82</b>	<b>22.34</b>	<b>35.25</b>	<b>19.65</b>	<b>125.14</b>	<b>12.43</b>	<b>60.99</b>	<b>0.0</b>	<b>8561.0</b>	<b>5640.7</b>

XX. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ

2018.12.06

	Үзүүлэлт	2017	2018	18/17 хувь
	Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо	30029	30528	101.6
	Бүх хэрэг	213	262	123.0
	Хүнийг санаатай алах гэмт хэрэг	3	4	133.3
	Хүчиндэх гэмт хэрэг	3	6	0.0
	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	7		0.0
	Дээрэмдэх гэмт хэрэг	2	1	50.0
	Булаалт	0	0	0.0
Хэргийн өнгө	Танхайн хэрэг	0	0	0.0
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	102	77	75.5
	Бусдын эд хөрөнгийн хулгай	34	103	302.9
	Малын хулгай	13	18	0.0
	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг	26	16	61.5
	Залилангийн хэрэг	6	10	166.7
	Албан тушаал	0	0	0.0
	Бусад	17	27	0.0
	Эмэгтэй хүн оролцсон	20	12	60.0
	Согтуугаар	34	41	120.6
нөхцөл	Бүлэглэж	9	22	244.4
	Хүүхэд оролцсон		12	0.0
	Илрээгүй хэрэг	54	120	222.2
	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	10	8	80.0
	Хөнгөн	142	166	116.9
хэргийн ангилал	Хүндэвтэр	30		0.0
	Хүнд	38	96	252.6
	Онц хүнд	3		0.0
	Гэмт хэрэгт холбогдогсод	155	163	105.2
	Учирсан бүх хохирол /сая.төг/	549.0	834.0	151.9
	Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/	320.7	269.2	83.9
	Илрүүлэлтийн хувь	63.8	49.8	78.1
	18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/	71	86	121.1

XX.ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

2018.12.06

сум	18 ба түүнээс дээш насны хүн	18 -аас дээш насны 10000 хүнд ногдох	Бүх хэрэг	Холбогдох	Хохирол /мян.төг/	Золгүй учрал	Хүн амь	хүчин	дээрэм	булаалт	танхай	бусдын бие махбодьд гэмтэл учруулсан	бусдын өмчийн хулгай	малын хулгай	Тээврийн хэрэгс-лийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг	гал түймэр	албан тушаал	Залилан	бусад
Дэлгэрцогт	1106	145	16	4								3	5	2	3				3
Дэрэн	1363	73	10	10								1	4	2	1			1	1
Говь-Угтаал	1068	94	10	9			1					3	4	1					1
Цагаандэлгэр	694	72	5	2								2	2	1					
Баянжаргалан	756	146	11	3								5	6						
Өндөршил	973	31	3	2									2					1	
Гурвансайхан	1449	90	13	8			1					6	4	1					1
Өлзийт	1607	31	5	3				1				2	1	1					
Хулд	1612	136	22	20				1				1	15		3				2
Луус	1239	105	13	7								5	5		2				1
Дэлгэрхангай	1489	60	9	7			1					6	2						
Сайхан-Овоо	1470	27	4	1				1				1	2						
Эрдэнэдалай	3685	41	15	9				1				9	2	2	1				
Сайнцагаан	10074	111	112	64			1	1	1			28	44	7	5			8	17
Адаацаг	1943	72	14	7				1				5	5	1	1				1
Бусад	0			7															
Бүгд	30528	86	262	163	0.0	0	4	6	1	0	0	77	103	18	16	0	0	10	27



**Материалыг бэлтгэсэн:**

**Т.Бямбасүрэн  
С. Доржханд  
Г.Ариунжаргал  
Н.Түвшинжаргал  
Б. Отгонсүрэн**

**Утас 70593714, 70593715**

**2018 оны 12 сарын 12**

**СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН**

**ДАРГА**

**Б.ЭНХТУЯА**